



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/410.

Есөнбулаг сум

Тусгай зөвшөөрөл шинээр олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2.1 дэх заалт, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.9 дэх хэсэг, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Согтууруулах ундааны худалдаанд тавигдах шаардлагыг хангаж, спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл авахаар материалаа ирүүлсэн аж ахуйн нэгжүүдэд тусгай зөвшөөрлийг хавсралтаар шинээр олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хууль тогтоомж, шаардлага журмыг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн газар (Д.Бүрэнбаатар), холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Алтангэрэл)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны
07 дугаар сарын 28-ны өдрийн 141 дүгээр
захирамжийн хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН АЖ АХУЙН НЭГЖҮҮД

Д/д	Сумын харьяалал	Аж ахуйн нэгжийн нэр	Дэлгүүрийн нэр	Байрлал	Худалдаа үйлчилгээний хэлбэр
1.	Еөнбулаг сум	Халгихын гол ХХК	Сэржповрон хүнсний дэлгүүр	Оргил баг	Худалдах
2.	Есөнбулаг сум	Гурван богдын оргил дэлгэрэх ХХК	Хасагт хайрханы оргил хүнсний дэлгүүр	Оргил баг	Худалдах
3.	Есөнбулаг сум	Хүслэн дөлгөөн жаргалант ХХК	Хишиг хүнсний дэлгүүр	Жинст баг	Худалдах
4.	Есөнбулаг сум	Зулзагат ихэр хутаг ХХК	Сувд супермаркет	Жинст баг	Худалдах
5.	Дэлгэр сум	ЭБИГ түмэн ХХК	Түмэн хүнсний дэлгүүр	Сумын төв	Худалдах